

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/170/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Угас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/156
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БОЛОРМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 01/ALBAN/01

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41,939,736.67</u>	<u>218,809,625.93</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,000.00	5,578,065.46
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	108,000.00	5,578,065.46
3121	Төгрөг	108,000.00	5,578,065.46
31211	Төрийн сангийн харилцах	-	5,369,618.46
31213	Арилжааны банк дахь харилцах	108,000.00	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		208,447.00
33	АВЛАГА	255,038.10	120,094,438.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,948.00	11,948.00
335	Бусад авлага	243,090.10	120,082,490.10
3351	Байгууллагаас авах авлага	90.10	120,081,490.10
3352	Хувь хүмүүсээс авах авлага	243,000.00	1,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,576,698.57	93,137,122.37
351	Түүхий эд материал	29,315,183.62	79,297,157.42
35110	Тусгай зориулалттай материал	15,006,854.12	30,119,954.12
35130	Эм боох материал	13,848,995.42	45,112,224.10
35300	Бэлэн бүтээгдэхүүн	459,334.08	4,064,979.20
354	Хангамжийн материал	12,261,514.95	13,839,964.95
35410	Бичиг хэргийн материал	606,390.00	787,690.00
35420	Аж ахуйн материал	4,908,414.08	5,457,564.08
35430	Сэлбэг хэрэгсэл	3,710,000.00	5,020,950.00
35440	Түлш, шатах тослох материал	218,070.87	542,270.87
35460	Хүнсний материал	1,201,140.00	413,990.00
35470	Бусад хангамжийн материал	1,617,500.00	1,617,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>380,357,523.74</u>	<u>1,680,956,718.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>380,357,523.74</u>	<u>1,680,956,718.04</u>
392	Биет хөрөнгө	<u>366,163,523.74</u>	<u>1,666,762,718.04</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	291,943,800.00	1,589,865,390.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,269,326.93)	(38,826,606.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,575,000.00	89,575,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,065,000.00)	(43,320,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	124,654,119.35	141,007,889.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,297,193.71)	(81,625,296.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,032,241.99	10,902,241.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,882,216.96)	(7,784,850.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө		6,460,000.00
39217	Ном	472,100.00	508,950.00
393	Биет бус хөрөнгө	14,194,000.00	14,194,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,394,000.00	14,394,000.00
39304	Хасагдуулга	(200,000.00)	(200,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>422,297,260.41</u>	<u>1,899,766,343.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>126,100.00</u>	<u>36,743,520.91</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	126,100.00	36,743,520.91
413	Өглөг	126,100.00	36,743,520.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		679,500.91
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	28,074,020.00
4136	Бусад өглөг	126,100.00	7,990,000.0
41361	Байгууллагад төлөх өглөг	126,100.00	7,990,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>422,171,160.41</u>	<u>1,863,022,823.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>422,171,160.41</u>	<u>1,863,022,823.06</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,103,311.04	218,103,311.04

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	218,103,311.04	218,103,311.04
512	Хуримтлагдсан үр дүн	(46,699,270.47)	1,394,152,392.18
51210	Өмнөх үеийн үр дүн	(46,699,270.47)	(46,699,270.47)
51220	Тайлант үеийн үр дүн		1,440,851,662.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,767,119.84	250,767,119.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>422,297,260.41</u>	<u>1,899,766,343.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416,283,716.47	2,106,737,042.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,271,391.47	1,442,243,639.11
120	Нийтлэг татварын бус орлого	57,936,991.47	1,442,243,639.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,936,991.47	1,442,243,639.11
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,936,991.47	1,442,243,639.11
122	Тусламжийн орлого	1,334,400.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	1,334,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	306,685,400.00	328,591,255.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	306,685,400.00	328,591,255.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,712,705.00	154,843,738.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,712,705.00	154,843,738.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,418,400.00	48,461,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,418,400.00	48,461,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,195,820.00	132,597,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,195,820.00	132,597,410.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	388,762,750.39	665,885,379.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,762,750.39	665,885,379.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,299,576.01	647,515,926.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,556,831.00	297,616,435.91
210101	Үндсэн цалин	232,556,831.00	297,616,435.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,181,939.98	33,904,359.54
210201	Тэтгэврийн даатгал	20,526,326.40	24,558,979.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,382,891.03	2,654,461.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,865,989.83	2,039,568.71
210204	Ажилгүйдлийн даатгал	400,610.52	422,851.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,006,122.20	4,228,498.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,758,280.00	30,249,947.00
210301	Гэрэл, цахилгаан	2,978,780.00	3,604,592.00
210302	Түлш, халаалт	23,760,000.00	26,645,355.00
210303	Цэвэр, бохир ус	19,500.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	21,873,156.69	138,732,081.69
210401	Бичиг хэрэг	908,350.00	2,660,450.00
210402	Тээвэр, шатахуун	14,142,895.33	23,744,594.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	880,000.00	385,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	953,500.00	715,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,988,411.36	111,227,037.59
2105	Нормативт зардал	26,899,523.79	72,839,227.32

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,142,520.19	61,166,632.32
210502	Хоол, хүнс	6,551,720.00	11,672,595.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,205,283.60	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,407,250.00	5,283,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	186,500.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,378,550.00	5,225,150.00
210604	Урсгал засвар	842,200.00	58,300.00
2107	Томилолт, зочны зардал	962,500.00	542,655.00
210702	Дотоод албан томилолт	962,500.00	542,655.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	798,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		798,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	156,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,180,094.55	67,548,920.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,915,438.00	46,505,904.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,264,656.55	21,043,016.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,463,174.38	18,369,453.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,463,174.38	17,361,453.00
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,463,174.38	17,361,453.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	27,520,966.08	1,440,851,662.65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,520,966.08	1,440,851,662.65

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрс үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	(73,488,092.74)	246,549,819.37
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	(73,488,092.74)	246,549,819.37
C07	Тайлант үеийн үр дүн			9,900,312.00	9,900,312.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	(46,699,270.47)	422,171,160.41
D01	2021 оны 01-р сарын 01-нээрс үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	(46,699,270.47)	422,171,160.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	(46,699,270.47)	422,171,160.41
D08	Тайлант үеийн үр дүн	-		1,440,851,662.65	1,440,851,662.65
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,394,152,392.18	1,863,022,823.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,012,325.00	544,412,003.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,012,325.00	544,412,003.10
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	306,685,400.00	328,591,255.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,712,705.00	5,788,138.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,712,705.00	5,788,138.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,418,400.00	48,461,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,418,400.00	48,461,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,195,820.00	161,571,610.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,195,820.00	161,571,610.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	356,904,325.00	538,797,087.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,904,325.00	538,797,087.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,441,150.62	520,427,634.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,556,831.00	296,936,935.00
210101	Үндсэн цалин	209,450,943.00	192,687,684.00
210102	Нэмэгдэл	12,838,372.00	63,219,438.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		41,029,813.00
210104	Урамшуулал	10,267,516.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,181,939.98	33,904,359.54
210201	Тэтгэврийн даатгал	27,781,090.59	23,899,302.21
210202	Тэтгэмжийн даатгал	388,303.26	3,021,917.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	303,921.16	2,015,780.06
210204	Ажилгүйдлийн даатгал	64,420.70	458,741.86
210205	Эрүүл мэндийн даатгал	644,204.27	4,508,618.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,758,280.00	30,249,947.00
210301	Гэрэл, цахилгаан	2,978,780.00	3,604,592.00
210302	Түлш, халаалт	23,760,000.00	26,645,355.00
210303	Цэвэр, бохир ус	19,500.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	17,609,759.84	24,068,978.50
210401	Бичиг хэрэг	999,350.00	3,216,697.00
210402	Тээвэр, шатахуун	14,360,409.84	19,012,281.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	615,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,225,000.00
2105	Нормативт зардал	16,156,451.80	67,719,833.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,688,451.80	61,974,038.00
210502	Хоол, хүнс	6,468,000.00	5,745,795.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,892,050.00	10,038,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,642,700.00	5,029,150.00

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,117,150.00	3,120,000.00
210604	Урсгал засвар	1,132,200.00	1,889,600.00
2107	Томилолт, зочны зардал	962,500.00	369,000.00
210702	Дотоод албан томилолт	962,500.00	369,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,480,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	156,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,843,338.00	57,139,831.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,843,338.00	57,139,831.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,463,174.38	18,369,453.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,463,174.38	17,361,453.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,463,174.38	17,361,453.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>108,000.00</u>	<u>5,614,915.46</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		36,850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		36,850.00
2200	Дотоод эх үүсвэрээр		36,850.00
223001	Бусад хөрөнгө	-	36,850.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	(36,850.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	108,000.0
23	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	108,000.0
2300	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(108,000.0)
230001	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	5,470,065.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	<u>108,000.00</u>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,000.00	5,578,065.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,436,400.00	383,988,141.54	13,448,258.46	96.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,436,400.00	383,988,141.54	13,448,258.46	96.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,436,400.00	366,626,688.54	30,809,711.46	92.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,856,900.00	251,677,221.00	6,179,679.00	97.60

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	161,190,000.00	147,427,970.00	13,762,030.00	91.46
210102	Нэмэгдэл	67,700,400.00	63,219,438.00	4,480,962.00	93.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,966,500.00	41,029,813.00	(12,063,313.00)	141.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,810,900.00	33,904,359.54	906,540.46	97.40
210201	Тэтгэврийн даатгал	24,495,700.00	23,899,302.21	596,397.79	97.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,578,200.00	3,021,917.11	(443,717.11)	117.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,063,000.00	2,015,780.06	47,219.94	97.71
210204	Ажилгүйдлийн даатгал	516,400.00	458,741.86	57,658.14	88.83
210205	Эрүүл мэндийн даатгал	5,157,600.00	4,508,618.30	648,981.70	87.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,265,200.00	30,249,947.00	17,015,253.00	64.00
210301	Гэрэл, цахилгаан	5,439,600.00	3,604,592.00	1,835,008.00	66.27
210302	Түлш, халаалт	41,600,000.00	26,645,355.00	14,954,645.00	64.05
210303	Цэвэр, бохир ус	225,600.00		225,600.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	24,514,200.00	23,798,770.00	715,430.00	97.08
210401	Бичиг хэрэг	999,600.00	3,216,697.00	(2,217,097.00)	321.80
210402	Тээвэр, шатахуун	21,015,000.00	18,742,073.00	2,272,927.00	89.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	999,600.00	615,000.00	384,600.00	61.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,225,000.00	275,000.00	81.67
2105	Нормативт зардал	19,389,200.00	17,541,885.00	1,847,315.00	90.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,889,200.00	11,796,090.00	93,110.00	99.22
210502	Хоол, хүнс	7,500,000.00	5,745,795.00	1,754,205.00	76.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,920,000.00	5,500,750.00	419,250.00	92.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,531,150.00	68,850.00	95.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,120,000.00	3,120,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	849,600.00	350,400.00	70.80
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	369,000.00	1,131,000.00	24.60
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	369,000.00	1,131,000.00	24.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	3,584,756.00	2,595,244.00	58.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	3,584,756.00	2,595,244.00	58.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	17,361,453.00	(17,361,453.00)	-
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,361,453.00	(17,361,453.00)	
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас төвлөрүүлэх		17,361,453.00	(17,361,453.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	36,850.00	(36,850.00)	-
223001	Бусад хөрөнгө	-	36,850.00	(36,850.00)	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	391,664,300.00	389,394,610.00	2,269,690.00	99.42
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	328,417,600.00	328,417,600.00	-	100.00

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,417,600.00	328,417,600.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,693,100.00	48,461,000.00	(5,767,900.00)	113.51
132001	Орон нутгийн төсвөөс	42,693,100.00	48,461,000.00	(5,767,900.00)	113.51
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,553,600.00	12,516,010.00	8,037,590.00	60.89
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,553,600.00	12,516,010.00	8,037,590.00	60.89

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны
		Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	154,808,946.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154,808,946.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,800,946.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,259,714.00
210101	Үндсэн цалин	45,259,714.00
2104	Хангамж, бараа материалын зардал	270,208.50
210402	Тээвэр, шатахуун	270,208.50
2105	Нормативт зардал	50,177,948.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,177,948.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,538,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,498,000.00
210604	Урсгал засвар	1,040,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,555,075.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,555,075.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	155,017,393.10
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	173,655.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	154,843,738.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	154,843,738.10

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөр ширээт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 18,368.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,776.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 13,269.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 9,952.0 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 5,099.0 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	108.0	5,578.1	5,470.1
Авлага	225.0	120,094.4	119,869.4
Бараа материал	41,576.7	93,137.1	51,560.4
Үндсэн хөрөнгө	380,357.5	1,680,956.7	1,300,599.2
Нийт хөрөнгө	422,297.2	1,899,766.3	1,477,469.1
Өр төлбөр	126.1	36,743.5	36,617.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	422,171.1	1,863,022.8	1,440,851.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	422,297.2	1,899,766.3	1,477,469.1

Авлага дансны үлдэгдэл 120,094.4 мянган төгрөг болж, 119,869.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжүүлэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлыг 120,081.4 мянган төгрөгөөр авлагад тусгасантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэлд Ажиллагсадтай холбоотой 11.9 мянган төгрөг, байгууллагаас авах 0.09 мянган төгрөгийн авлага, хувь хүнээс авах 1.0 мянган төгрөг, нийт 13.0 мянган төгрөгийн он дамжсан авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,137.1 мянган төгрөг болж, 51,560.4 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 121,617.2 мянган төгрөгийн дархлаажуулалтын вакцин, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн Удирдах зөвлөлийн тогтоолоор байгууллагын Эргэлтийн эмийн сангаас 2,000.0 мянган төгрөг, Өндөр ширээт сумын Онцгой комиссоос 576.0 мянган төгрөгийн малын мах, Иргэн Д.Санжмятаваас 254.5 мянган төгрөгийн хангамжийн материал, Иргэн Б.Уламбаяраас 995.0 мянган төгрөгийн хангамжийн материал, нийт 125,442.7 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна.

Бараа материалын дансанд тооллогоор 63.5 мянган төгрөгийн бараа материал нэмж бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,680,956.7 мянган төгрөг болж, 1,300,599,2 мянган төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Иргэн Санжментаваас 6,460.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Эрүүл мэндийн газраас 8,872.4 мянган төгрөгийн 3 ширхэг компьютер, вакцин зөөврийн сав, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, Аймгийн Засаг даргын Тамгын газраас хандиваар ирсэн 3,483.3 мянган төгрөгийн дархлаажуулалтын вакцины хөргөгч, улсын төсвийн санхүүжилтээр баригдсан 1,297,921.6 мянган төгрөгийн өртөгтэй, 10 орны хүчин чадалтай, 2 давхар эмнэлгийн барилга мөн моргийн барилга байгууламжаар нэмэгдсэн.

Өр төлбөр дансны үлдэгдэл 36,743.5 мянган төгрөг болж, 36,617.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр төлбөр дансны үлдэгдэлд НДШ-д өгөх 679.5 мянган төгрөг, Нью ремеди ХХК-д өгөх 6,786.9 мянган төгрөгийн, Монгол эм импекс ХХК-д өгөх 20,856.5 мянган төгрөг, Нигүүн арвижих ХХК-д өгөх 7,990.0 мянган төгрөг, Тэгш анар ХХК-д өгөх 430.6 мянган төгрөг, нийт 36,743.5 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,690,453.3 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн данс 1,297,921.6 мянган төгрөгийн барилга байгууламжаар, бараа материалын данс хандиваар ирсэн 125,506.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжүүлэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлыг 120,081.4 мянган төгрөгөөр орлогод бүртгэсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 237,726.5 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормавтивт зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм, нэг хэрэглэдэг хувцас хэрэглэлийн зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 432,230.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 432,230.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 40,566.1 мянган төгрөгөөр бууруулж, 391,664.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391,664.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 328,417.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 42,693.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,553.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 389,394.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсвөөс 328,417.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 48,461.0 мянган төгрөгийн, эрүүл мэндийн сангаас 12,516.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 366,663.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 17,361.4 мянган төгрөг, улсын төсөвт 5,686.1 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өөр хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн даатгалын 151,264.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Мөн нэмэлтээр Ковид 19-тэй холбоотой түргэвчилсэн оношилгоо шинжилгээний төлбөрийн орлого 2,097.6 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын А/659 дугаар тушаалаар 300.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн газраас 1,181.6 мянган төгрөг, нийт 3,579.2 мянган төгрөгийг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 155,017.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 154,843.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 208.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,690,453.3 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн данс 1,297,921.6 мянган төгрөгийн барилга байгууламжаар, бараа материалын данс хандиваар ирсэн 125,506.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Өндөр ширээт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 499,559.9 мянган төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагт ил тод

байршуулахаас 424,934.3 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 21,175.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	243.0	1	243.0	-	-	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	20,932.6	2	20,932.6	-	-	100
Нийт дүн	3	21,175.6	3	21,175.6	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөр ширээт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 434,270.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,460.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 454.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2,421.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 424,934.3 мянган төгрөгийн шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын дансанд хандив тусламжаар ирсэн 6,460.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах", санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны цалингаас ХХОАТ чөлөөлөлгүй тооцоноос 441.4 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллага нь 2019 онд үүссэн 1 байгууллагаас авах 0.09 мянган төгрөгийн, 2 хувь хүнээс авах 13.0 мянган төгрөгийн, нийт 13.0 мянган төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй байна. Он дамжсан авлагын эзэн холбогдогчоор авлагыг төлж барагдуулах арга хэмжээ авагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 3 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 2,421.5 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 115 ширхэг 104,329.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Өндөр ширээт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 499,559.9 мянган төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 424,934.3 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Хандиваар ирсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн	1	6,460.0	1	6,460.0						
2	Авлага үүсгэсэн, он дамжсан авлагыг барагдуулаагүй	1	13.0			1	13.0				
3	Цалинг буруу тооцоолж олгосон	1	441.4			1	441.4				
4	Худалдан авалтыг Татварынэ цахим системд бүртгээгүй, И баримтаар баталгаажуулаагүй	1	2,421.5					1	2,421.5		
5	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		5	9,335.9	1	6,460.0	2	454.4	1	2,421.5	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	424,934.3							1	424,934.3
Дүн		1	424,934.3							1	424,934.3
Нийт дүн		6	434,270.2	1	6,460.0	2	454.4	1	2,421.5	2	424,934.3